



МАНДАЛ
ДААТГАЛ

15
ЖИЛ


| **ЖИЛИЙН**
тайлан 2025

САНХҮҮГИЙН ҮР ДҮН

АШИГТ АЖИЛЛАГАА: МАНДАЛ ДААТГАЛ ХК

“Мандал даатгал” ХК нь 2025 онд **татварын дараах 13.1 тэрбумын цэвэр ашгийн** хэмжээгээрээ салбартаа тэргүүлэх байр суурийг хадгалсан. Ийнхүү цэвэр ашгаар тэргүүлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь хөрөнгө оруулалтын орлого **9.5 тэрбум** байсантай холбоотой бөгөөд үүний шалтгаан нь мөнгөн хөрөнгөө зохистойгоор хөрөнгө оруулалтын өгөөж ихтэй, хөрөнгө оруулалтын эрсдэл багатай хэрэгслүүдэд байршуулсан.

График 1. Мандал даатгалын ашигт ажиллагаа



Салбарын дунджаас өндөр өөрийн хөрөнгийн өгөөжтэй, өсөлт өндөр байгаа нь “Мандал Даатгал” ХК хөрөнгийн удирдлага сайн байгааг илтгэж байна.

График 2. “Мандал Даатгал” ХК болон салбарын өөрийн хөрөнгийн өгөөжийн




НИЙТ ХӨРӨНГӨ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2025 онд нийт хөрөнгийн хэмжээ **137.8 тэрбум төгрөгт** хүрч өмнөх оноос 15.2 тэрбум төгрөгөөр буюу 12.4%-иар нэмэгдсэн бөгөөд үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд нь **даатгалын үйл ажиллагааны ашиг, цэвэр ашиг, хөрөнгө оруулалтын** өсөлтүүд юм. “Мандал Даатгал” ХК нь 2011 онд 6.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол одоогийн байдлаар 21 дахин их хөрөнгөтэй болсон байна. Нийт хөрөнгө сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар 20%-ийн өсөлттэйгээр нэмэгдсэн юм.

НИЙТ ХӨРӨНГӨ /САЛБАР/

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 2025 оны жилийн эцсийн байдлаар **669 тэрбум** төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 71.8 тэрбум төгрөгөөр буюу 12%-иар өссөн. Үүнд **хөрөнгө оруулалтын дүн** өмнөх оны мөн үеэс 51.1 тэрбум төгрөгөөр буюу 15.3%-иар өссөн ба харин **даатгалын хөрөнгө** 3,1 тэрбум төгрөгөөр буюу 3%-иар буурсан үзүүлэлттэй байна. Нийт даатгалын компаниудын хөрөнгө нь сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **17%-ийн** өсөлттэйгээр нэмэгдсэн юм.

График 3. Мандал даатгал болон салбарын нийт хөрөнгийн харьцуулалт




МӨНГӨН ХӨРӨНГӨ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2025 онд мөнгөн хөрөнгийн хэмжээ **79.6 тэрбум** төгрөгт хүрч, өмнөх оныхоос 10.5 тэрбум төгрөгөөр буюу 15%-иар нэмэгдсэн. 2011 оноос хойш хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ салбартаа тэргүүлж, Монголын хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүргээ гүйцэтгэсээр байна. Мөнгөн хөрөнгө маань сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **21%**-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

МӨНГӨН ХӨРӨНГӨ /САЛБАР/

Ердийн даатгалын компаниудын мөнгөн хөрөнгийн хэмжээ 2025 оны жилийн эцсийн байдлаар **415.2 тэрбум** төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 58.2 тэрбум төгрөгөөр буюу 16%-иар өссөн байна. Мөнгөн хөрөнгө нь сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **19%**-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

График 4. “Мандал Даатгал” ХК болон салбарын мөнгөн хөрөнгийн харьцуулалт



Ердийн даатгалын компаниудын хөрөнгө оруулалтыг авч үзвэл хадгаламж, хадгаламжийн сертификатад оруулах хөрөнгө оруулалт хамгийн өсөлттэй байгаа бол нөгөөтээгүүр хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт хамгийн бага байгаа юм.

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2025 онд “Мандал Даатгал” ХК-ийн хувьд нийт хураамжийн орлого **155.6 тэрбум** төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 10.4 тэрбум төгрөгөөр буюу 7.2%-ийн өсөлттэй тайлагналаа. Нийт хураамжийн орлого маань сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **34%**-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн бөгөөд салбарт эзлэх байр сууриа бататган эхний байранд орлоо.

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО /МАНДАЛ ДААТГАЛ ХК/-БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР/

2025 онд “Мандал Даатгал” ХК-ийн нийт хураамжийн орлогыг бүтээгдэхүүний хэлбэрээр нь задлан харвал, хөрөнгийн даатгал хамгийн их буюу **53.3%** ба үүний дараа гэнэтийн осол, эмчилгээний даатгал **21.2%**, авто тээврийн хэрэгслийн даатгал **12.5%**, хариуцлагын даатгал **6.1%**, барилга угсралтын даатгал **2.6%**, бусад даатгалууд **4.3%** тус тус эзэлж байгаа юм.

График 5. “Мандал Даатгал” ХК-ийн нийт хураамжийн



НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО/САЛБАР/-БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР


График 6. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого



ДААТГУУЛАГЧДЫН ТОО /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2025 онд **69,290** хувь хүн болон албан байгууллагын эрсдэлийг даатгаж ажиллалаа. Энэ нь өмнөх оныхоос **3%-иар өссөн** үзүүлэлт юм.

График 7. Мандал даатгалын нийт даатгуулагчдын тоо




НӨХӨН ТӨЛБӨРИЙН НӨӨЦ САН /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ өмнөх оноос **4.3 тэрбум төгрөгөөр өсч, 13.6 тэрбум** төгрөгт хүрсэн байна. 2025 онд компанийн нөөц сангийн хүрэлцээний түвшин хангалттай түвшинд байна. Сүүлийн 5 жилийн нийлмэл өсөлт нь **18%**-тай байна.

НӨХӨН ТӨЛБӨРИЙН НӨӨЦ САН /САЛБАР/

Ердийн даатгалын компаниудын хувьд нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ өмнөх оноос 19.3 тэрбум төгрөгөөр буурч, **73.7 тэрбум** төгрөгт хүрсэн байна. Сүүлийн 5 жилийн нийлмэл өсөлт нь **10%**-тай байна.

График 8. "Мандал Даатгал" ХК болон салбарын нөөц сангийн




НӨХӨН ТӨЛБӨР /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Бид харилцагчдаас хүлээн авсан эрсдэлийн багцын томоохон хэсгийг олон улсын давхар даатгалын зах зээл дээр байршуулж ажилладаг билээ. Ингэснээр, компанийн төлбөрийн чадварыг хамгаалж, харилцагчдын нөхөн төлбөр найдвартай, баталгаатай төлөгдөх нөхцөлийг бүрдүүлдэг.

2025 онд нийт 27.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон ба өмнөх оныхоосоо **10 тэрбум төгрөгөөр буюу 58%-иар** нэмэгдсэн. Бүтээгдэхүүний хэлбэрээр задлан харвал гэнэтийн осол, эмчилгээний даатгал 12.1 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 160%-иар нэмэгдсэн байна. Сүүлийн 5 жилийн нийлмэл өсөлт нь **35%**-тай байна.


НӨХӨН ТӨЛБӨР /САЛБАР/

2025 онд нийт **189.1 тэрбум** төгрөгийн нөхөн төлбөр олгосон ба өмнөх оныхоосоо **30.7 тэрбум** төгрөгөөр буюу **19.4%**-иар нэмэгдсэн. Бүтээгдэхүүний хэлбэрээр задлан харвал хамгийн өндөр нөхөн төлбөр бүхий, авто тээврийн хэрэгслийн даатгал **47.7 тэрбум** төгрөг, жолоочийн хариуцлагын даатгал **46.6 тэрбум** төгрөг, гэнэтийн осол, эмчилгээний даатгал **37.7 тэрбум** төгрөг олгосон ба сүүлийн 5 жилийн нийлмэл өсөлт нь **22%**-тай байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2025 онд үйл ажиллагааны зардал **13.4 тэрбум** төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 685 сая төгрөг буюу **5%**-иар өссөн. Үйл ажиллагааны зардал маань сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **13%**-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ /САЛБАР/

Ердийн даатгалын компаниудын үйл ажиллагааны зардал 2025 онд 137.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 18.5 тэрбум төгрөгөөр буюу **16%**-иар өссөн байна. Үйл ажиллагааны зардал нь сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **33%**-ийн өсөлттэйгөөр нэмэгдсэн юм.

График 9. "Мандал Даатгал" ХК болон салбарын нөхөн төлбөрийн харьцуулалт




График 10. "Мандал Даатгал" ХК болон салбарын үйл ажиллагааны зардлын харьцуулалт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО /МАНДАЛ ДААТГАЛ ХК/


“Мандал Даатгал” ХК нь хөрөнгө оруулалтын багцын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Хөрөнгө оруулалтын удирдлага нь компанийн хөрөнгө оруулалтын багцыг өдөр бүр тогтмол хянан, эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг.

2025 онд хөрөнгө оруулалтын орлого **9.5 тэрбум** төгрөгт хүрч өмнөх оныхоосоо 0.6 тэрбум төгрөгөөр буюу 7%-иар өсч, төлөвлөгөө **8.81-ээс 0.69 тэрбум** төгрөгөөр их буюу биелэлт **108%**-тай байсан. Хөрөнгө оруулалтын орлого сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **19%**-ийн өсөлттэйгээр нэмэгдсэн юм.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО /САЛБАР/

Ердийн даатгалын компаниудын хөрөнгө оруулалтын орлого 2025 онд **44.7 тэрбум** төгрөгт хүрч өмнөх оныхоосоо **6.7 тэрбум** төгрөгөөр буюу 17%-иар өссөн байна. Хөрөнгө оруулалтын орлого нь сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **18%**-ийн өсөлттэйгээр нэмэгдсэн юм.

График 11. “Мандал Даатгал” ХК болон салбарын хөрөнгө оруулалтын орлогын харьцуулалт




ЦЭВЭР АШИГ /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2025 онд компанийн цэвэр ашиг **13.1 тэрбум** төгрөгийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оныхоос **4.8 тэрбум** төгрөгөөр буюу **39%**-иар өссөн. Компанийн цэвэр ашгийн үр дүн, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн **ногдол ашиг тараахаар шийдвэрлэв**. Компанийн цэвэр ашгийн үзүүлэлт сүүлийн 5 жилийн хугацаанд тогтмол эерэг үзүүлэлттэй гарсан ба сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **24%**-ийн өсөлттэй байлаа.

ЦЭВЭР АШИГ /САЛБАР/

Ердийн даатгалын компаниудын цэвэр ашиг 2025 онд **54.3 тэрбум** төгрөгт хүрч өмнөх оныхоосоо **15.2 тэрбум** төгрөг буюу **39%**-иар өссөн байна. Цэвэр ашиг нь сүүлийн 5 жилийн турш, жилд дунджаар **54%**-ийн өсөлттэй байв.

График 12. “Мандал Даатгал” ХК болон салбарын цэвэр ашгийн харьцуулалт




НИЙЛМЭЛ ХАРЬЦАА /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

2025 онд нийлмэл харьцаа **91.3%**-д хүрсэн. Тус харьцаа буурах тусам ашигт ажиллагаа сайжирч байгааг харуулдаг. 2025 оны ердийн даатгалын компаниудын дундаж нийлмэл харьцаа **100.6%** байсан ба “Мандал Даатгал” ХК-ийнх тус түвшнээс 9.3%-иар бага байлаа. 2025 онд нийлмэл харьцаа буурахад нөлөөлсөн гол үзүүлэлт болох зардлын харьцаа **10%**-иар багассантай холбоотой буурсан үзүүлэлттэй байгаа юм.

НИЙЛМЭЛ ХАРЬЦАА /САЛБАР/

Ердийн даатгалын компаниудын нийлмэл харьцаа 2025 онд **100.6%**-д хүрсэн.

График 13. “Мандал Даатгал” ХК болон салбарын нийлмэл харьцааг харьцуулсан байдал




ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТҮВШИН /МАНДАЛ ДААТГАЛ ХК/

Төлбөрийн чадварын харьцаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх болон ирээдүйд учрах томоохон эрсдэлийг даахад хүрэлцэхүйц хөрөнгөтэй эсэхийг харуулдаг үзүүлэлт билээ.

2025 онд төлбөрийн чадварын түвшин хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар **хангалттай тайлагнагдсан**. Уг үзүүлэлт нь 2024 оноос харьцаагаар биш түвшингээр хэмжигддэг болсон. Өнгөрсөн жилүүдэд Санхүүгийн зохицуулах хорооноос (СЗХ) тавигдах шаардлагыг **10%**-иар хангаж ажилласан.

График 13. “Мандал Даатгал” ХК болон салбарын нийлмэл харьцааг харьцуулсан байдал



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багц бүрдүүлэлтийн төлөвлөгөөг макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал болон хөрөнгө оруулалтын боломжууд дээр үндэслэн эрсдэл багатай, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөд хөрөнгө оруулалт хийдэг.

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын гол үзүүлэлтүүд

	2024	2025	/тэр.төг/
Мөнгөн хөрөнгө	69.1	79.6	15%
Хөрөнгө оруулалтын орлого	8.9	9.5	7%

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын мэдээлэл

	2025	Хувь
Бэлэн мөнгө	2.2	2.8%
Хадгаламж, хадгаламжийн сертификат	55.8	70.1%
Үнэт цаас /цэвэр/	21.6	27.1%
Нийт	79.6	100%

Мандал даатгал
Хөрөнгө оруулалтын өгөөж

16%

Ердийн даатгалын салбарын дундаж
Хөрөнгө оруулалтын өгөөж

12%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ


2018 оны 9-р сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO (Initial Public Offering) хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25%-ийг санал болгон нийт 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан хувьцаат компани болсон түүхтэй билээ.

ХУВЬЦААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 3. Хувьцааны гол үзүүлэлтүүд

Зах зээлийн үнэлгээ	43.23 тэр.төг
Нийт хувьцааны тоо	624,301,600 ширхэг
Хаалтын ханш 12/31/2025	₮69.25

Нэгж хувьцааны ханш 2025 онд **70.50** төгрөгөөр эхэлсэн бол оны эцэст буюу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар **69.25** төгрөг болж компанийн зах зээлийн үнэлгээ 43.23 тэрбум төгрөгт хүрч хаагдсан байна.



ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

“Мандал даатгал” ХК-ийн хувьцаа нь MNDL нэршлээр Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд арилжаалагдаж байна. Энэ ангилалд сүүлийн жилд 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай, нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх зэрэг чанарын үзүүлэлт хангасан компаниуд багтдаг.

Монголын Хөрөнгийн Биржийн компаниуд дундаас **2025 оны** идэвхтэй арилжаалагдсан ширхэгээр 30 компаниас **300 сая** ширхэг арилжаалагдаж 1 дүгээрт, арилжааны дүнгээр 6 дугаарт жагссан.

Хүснэгт 4. Хувьцааны арилжааны товч мэдээлэл

Нийт арилжааны дүн	1.7 тэр.төг
Өдрийн дундаж арилжаа	87.3 сая.төг
Өдрийн дундаж арилжааны ширхэг	1.2 сая.ширхэг
52 долоо хоног өндөр ханш	₮85.0
52 долоо хоног бага ханш	₮58.0

Зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтээрээ манлайлсан жишиг ТОП-20 компанийн индексийн үзүүлэлтэд 2019 онд багтсанаас хойш 6 жилийн турш тасралтгүй энэхүү индексэд багтаж байна. ТОП-20 индекс нь 2025 онд 51,455-с эхэлж оны эцэст 54,478 нэгжээр хаагджээ.

График 15. ТОП-20 индекс ба “Мандал Даатгал” ХК-ийн үнийн хамаарал





График 16. Дундаж арилжааны ширхэг болон үнийн хамаарал



Эх сурвалж: МХБ

НОГДОЛ АШИГ БА НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгож хөрөнгө татсанаас хойш санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан жил бүр ногдол ашиг олгосон бөгөөд 2018, 2019, 2020, 2021, 2024, 2025 оны цэвэр ашгаас тус бүр 16%, 43%, 41%, 33%, 61%, 67%-ийн ногдол ашиг олгох шийдвэр гаргасан.

Хүснэгт 3. Ногдол ашгийн мэдээлэл

2019	4	624,301,600	2,497,206,400	5,820,239	43%
2020	3	624,301,600	1,872,904,800	4,588,055	41%
2021	3	624,301,600	1,872,904,800	5,607,013	33%
2022	-	624,301,600	-	4,084,406	-
2023	-	624,301,600	-	5,814,869	-
2024	8.1	624,301,600	5,056,842,960	8,331,786	61%
2025	14.7	624,301,600	8,742,095,304	13,086,498	67%

Бид 2025 оны цэвэр ашгийн 66.8%-ийг **ногдол ашиг** олгохоор шийдвэрлэсэн.

АНДЕРРАЙТИНГ БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ЗӨВ ЭРСДЭЛИЙН БАГЦ БҮРДҮҮЛЭХ

Мандал Даатгал ХК нь өөрийн Андеррайтингийн бодлогын хүрээнд даатгалын бүтээгдэхүүн бүрийг дараах 3 үндсэн шалгуураар үнэлж, бүтээгдэхүүний зөв багцыг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Үүнд:

- Зах зээлийн багтаамж
- Хохирлын харьцаа
- Андеррайтингийн туршлага

Зөв эрсдэлийн багц бүрдүүлэх нь нэг талаас компанийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нөгөө талаас даатгуулагчдад нөхөн төлбөрийг түргэн шуурхай, найдвартай олгоход чиглэж буй юм.

ДААТГАЛЫН БОЛОН ЭРСДЭЛ БУУРУУЛАХ ИНЖЕНЕРИЙН ШИЙДЭЛ САНАЛ БОЛГОХ

Манай мэргэжлийн инженерийн баг даатгуулагчийн эрсдэлийг үнэлж үзсэний үндсэн дээр тухайлсан даатгалын шийдэл болон даатгуулагчийн эрсдэлийг бууруулах аргачлал, төлөвлөгөөг боловсруулж санал болгож байна. Улмаар даатгуулагчийн болон компанийн аль алиных нь эрсдэл буурч харилцан өгөөжтэй хамтран ажиллах үндэс бий болох юм.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ НУТАГШУУЛАХ, АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ

Бид 2018 оноос голлох даатгалын бүтээгдэхүүнүүдийн гэрээг Lloyds', Munich Re зэрэг олон улсад даатгалын гэрээний стандарт тогтоогч мэргэжлийн оролцогчдын туршлага болон Монголын даатгалын зах зээлийн онцлог, шинж чанарт нийцүүлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 16 стандарт бүтээгдэхүүнтэй болсон байна. Үргэлжлүүлэн олон улсын туршлагатай андеррайтеруудтай хамтарч андеррайтингийн үйл ажиллагааг автоматжуулах чиглэлд ажиллаж байна.

АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТООГООР

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны “Мандал даатгал” ХК-ийн санхүүгийн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд харуулав:

Санхүүгийн үзүүлэлтүүд /сая төгрөг/	2024	2025
Нийт гэрээний тоо	82,494	82,335
Нийт хураамжийн орлого	145,199	155,637
Нийт нөхөн төлбөрийн дүн	17,350	27,257
Хохирлын харьцаа	46%	52%
Хийсэн эрсдэлийн үнэлгээний тоо	74	41

Онцлох өөрчлөлт, хөгжүүлэлт

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2020 оноос харилцагч нартаа даатгалын бүтээгдэхүүнээс гадна эрсдэлийн удирдлагын цогц үйлчилгээг санал болгож ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг нийцүүлсэн стандартууд:

1. Олон улсад эрсдэлийн үнэлгээ, удирдлагын үйлчилгээ үзүүлэгч FM Global, Cunningham Lindsey, Tysers Risk Management зэрэг компаниудын арга аргачлал
2. MNS ISO 31010:2011 “Эрсдэлийн Менежментийн Стандарт”
3. Монгол улсын хөдөлмөрийн сайдын тушаалаар батлагдсан “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж”
4. Монгол улсын Галын аюулгүй байдлын дүрэм, журам, стандарт
5. Монгол улсын стандарт MNS5566:2020 Ажахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид галунтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм

Даатгуулагч нарт санал болгож буй эрсдэлийн удирдлагын үйлчилгээнүүд:

Эрсдэлийн үнэлгээ хийж зөвлөмж өгөх

- Хөрөнгийн эрсдэлийн үнэлгээ
- Тоног төхөөрөмжийн эрсдэлийн үнэлгээ
- Гал болон цахилгааны эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт:

- Галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдал
- Хөдөлмөрийн аюулгүй байдал

Эрсдэл бууруулах ажлыг удирдан зохион байгуулах:

- Эрсдэл бууруулах ажлын төсвийн тооцоолол, судалгаа
- Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн хяналт
- Гүйцэтгэлийн дараах явцын хяналт

БАГЦЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



Бид өөрсдийн андеррайтингийн туршлага, давууталд үндэслэн бүтээгдэхүүний багцаа бүрдүүлдэг ба голлох 3 бүтээгдэхүүний хувьд ялгарах онцлогуудыг дурдвал:

1. Авто тээврийн хэрэгслийн даатгал

- Харилцагчийн сегмент бүрд зориулсан тусгай бүтээгдэхүүнүүд
- Эрсдэл багатай харилцагчийг урамшуулах систем
- Баталгаат засварын бирж
- Эрсдэлд суурилсан үнэ тооцоолол
- Тээврийн хэрэгслийн осол, хохирлын шалтгаан тодорхойлох гэрээт экспертүүд

2. Хөрөнгийн даатгал

- Олон улсын стандартад нийцүүлэн гаргасан бүтээгдэхүүн, гэрээний нөхцөл
- Даатгуулагчийн эрсдэлийн түвшинг үнэлэх, эрсдэл бууруулах ажлын зөвлөмж өгөх мэргэжлийн инженерийн баг
- Гал, цахилгаан, сангийн чиглэлийн эрсдэлийн удирдлагын сургалт
- Эрсдэлд суурилсан үнэ тооцоолол
- Даатгуулагчид учирч болох хамгийн их эрсдэл (PML)-ийн тооцоолол

3. Жаргалан эрүүл мэндийн даатгал

- Эрүүл мэндийн даатгалаар мэргэшсэн андеррайтеруудын баг
- Нөхөн төлбөр хариуцсан мэргэжлийн эмч нарын баг
- Монголд хамгийн том эмнэлэгийн сүлжээ
- Эмнэлэг дээрх харилцаа, үйлчилгээ хариуцсан тусгай менежер
- Эрүүл мэндийн даатгалын тусгай лавлах

ХУРААМЖ ТООЦООЛУУР

Бид 2019 оноос доорх даатгалын бүтээгдэхүүнүүдийн хүрээнд эрсдэлийн дата мэдээлэлд үндэслэн хураамжийн дүнг тооцоолдог моделийг боловсруулан андеррайтингийн үйл ажиллагаандаа ашиглаж байна:

- Үл хөдлөх хөрөнгийн даатгал
- Тээврийн хэрэгслийн даатгал
- Машин механизмын даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Тоног төхөөрөмжийн даатгал
- Ажилчдын осол, нөхөн олговрын даатгал
- Галын даатгал

Андеррайтингийн тоон үзүүлэлтүүд

ХУРААМЖИЙН ОРЛОГО

2025 оны 155.6 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлогыг бүтээгдэхүүний төрлөөр ангилж харвал дараах бүтэцтэй байна.

Хураамжийн орлого даатгалын хэлбэрээр	2024		2025	
	Сая төгрөг	Хувь	Сая төгрөг	Хувь
Авто тээврийн хэрэгслийн даатгал	20,855	14%	19,502	13%
Хариуцлагын даатгал	14,537	10%	9,575	6%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	19,673	14%	32,969	21%
Хөрөнгийн даатгал	72,925	50%	82,892	53%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	1,069	1%	590	0%
Санхүүгийн даатгал	1,087	1%	860	1%
Бусад	15,054	10%	9,249	6%
Нийт	145,199	100%	155,637	100%

Дээрх хүснэгтийг өмнөх онтой харьцуулан харвал Хөрөнгийн даатгалын хувьд 14%, Эрүүл мэндийн даатгалын хувьд 68% орчим хувиар өссөн бөгөөд Даатгалын нийт хураамжийн орлого 7% өссөн үзүүлэлттэй байна.

НӨХӨН ТӨЛБӨР

Мандал даатгал ХК нь 2025 онд нийт 13,085 даатгалын тохиолдолд нийт 27.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бөгөөд даатгалын тохиолдлын тоог даатгалын хэлбэрээр өмнөх онтой харьцуулан харвал дараах байдалтай байна.

Нөхөн төлбөр даатгалын хэлбэрээр	2024		2025	
	Сая төгрөг	Хувь	Сая төгрөг	Хувь
Автотээврийн хэрэгслийн даатгал	6,637	38%	5,649	20%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	7,518	43%	19,585	72%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	1,530	9%	699.7	3%
Хөрөнгийн даатгал	1,027	6%	1,016.8	4%
Хариуцлагын даатгал	220	1%	153.7	1%
Бусад	417	2%	309.0	1%
Нийт	17,350	100%	27,413	100%

2025 онд “Мандал Даатгал” ХК нь нийт 27.4 тэрбум төгрөгийн 5 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг давхар даатгагчаар төлүүлсэн бол үлдсэн 26 тэрбум төгрөг буюу 95 хувийг дангаараа хариуцан нөхөн төлбөр олгосон байна.

БАГЦЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Компанийн 2025 оны хохирлын харьцаа өмнөх оныхоос 6%-иар өсч 52% болсон үр дүнтэй байна. Нөхөн төлбөрийг бүтээгдэхүүнээр задлан харвал Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалд олгосон нийт нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх онтой харьцуулбал дунджаар 183%-иар өссөн.

Хохирлын харьцаа, даатгалын хэлбэрээр	2024	2025
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	58%	70%
Барилга угсралтын даатгал	0%	0%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	42%	35%
Хөрөнгийн даатгал	11%	11%
Хариуцлагын даатгал	22%	15%
Бусад	106%	75%
Нийт	46%	52%

НӨӨЦ САН ТООЦООЛОЛ

“Мандал Даатгал” ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны (СЗХ) 2025 оны 2-р сарын 25-ны өдрийн №66 тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн Хавсралт №3, “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу нөөц сангийн тооцооллыг хийдэг.

- 2025 оны эцэст 13.5 тэрбум төгрөгийн нөөц сан байгуулсан.
- Мөн нөөц сан тооцооллын хүрээнд 2020 оноос эхлэн нөөц сангийн зохист түвшинг тодорхойлж эхэлсэн ба 2025 оны нөөц сангийн хэмжээ хүрэлцээтэй түвшинд байна.
- Нөөц сангийн хэмжээг 2021 оноос хойш харьцуулан харвал дараах байдалтай байна.



ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

Төлбөрийн чадварын харьцаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх болон ирээдүйд учрах томоохон эрсдэлийг даахад хүрэлцэхүйц хөрөнгөтэй эсэхийг харуулдаг үзүүлэлт билээ. 2025 онд төлбөрийн чадварын түвшин хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай тайлагнагдсан.

Даатгагчийн нэр	2023	2024	2025
Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа	377.2%	313.5%	337.1%
Хөрөнгийн хүрэлцээт байдлын байвал зохих доод харьцаа	216.7%	318.7%	344.1%
Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа	13.5%	6.2%	6.1%
Төлбөрийн чадварын түвшин	2-р түвшин	2-р түвшин	2-р түвшин

ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Даатгалын компани даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгахыг “Давхар даатгал” гэнэ. Энгийнээр давхар даатгал нь даатгалын компанийн даатгал юм.

Мандал Даатгал ХК нь өөрийн санхүүгийн чадавхаас давсан эсхүл хариуцах сонирхлоос гадуурх эрсдэлүүдийг олон улсын зэрэглэл тогтоох агентлаг A.M.Best Company-ийн “A-”; S&P, Fitch Group-ийн “BBB”; Moody’s Corporation-ийн “Baa”-аас дээш үнэлгээтэй давхар даатгагчдад багцлан эсхүл эрсдэл тус бүрээр үнэлэн давхар даатгуулан ажиллаж байна.




ТРИТИ ДАВХАР ДААТГАЛ

Даатгалын компани өөрийн сонгосон эрсдэлүүдийн хувьд оновчтой хэмжээний давхар даатгалын хамгаалалттай байх зорилгоор тухайн хамгаалалтын бүхий л нөхцөлийг давхар даатгагчидтай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр гэрээт давхар даатгалын хамгаалалтыг худалдан авдаг. Бид дэлхийд хураамжийн орлогоороо эхний тавд жагсдаг Франц Улсын давхар даатгагч Скор РЭ, Герман Улсын давхар даатгагч Ханновэр РЭ, Монгол Улсын давхар даатгагч Үндэсний Давхар Даатгал Хувьцаат Компанитай гэрээлэн, хөрөнгө, хөрөнгийг дагасан бизнес тасалдал, барилга, угсралтын бүх эрсдэл, байгууллагын ерөнхий хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, мэргэжлийн хариуцлага, ажил олгогчийн хариуцлага, хүнд даац, тусгай зориулалтын машин механизм, ачаа тээврийн гээд нийт 8 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг давхар даатгуулан ажиллаж байна. Компанийн трити давхар даатгалын гэрээний хамгаалалтыг дор хүснэгтэд үзүүлэв.

Бүтээгдэхүүний төрөл	Дэд хязгаар /USD/
Хүнд даац, тусгай зориулалтын машин механизмын даатгал	2,000,000

Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал	
Бүтээгдэхүүний хариуцлагын даатгал	
Мэргэжлийн хариуцлагын даатгал	3,000,000
Ажил олгогчийн хариуцлагын даатгал	
Ачаа тээврийн даатгал	
Хөрөнгийн даатгал	5,000,000
Барилга угсралтын бүх эрсдэлийн даатгал	

Үүнээс гадна, шаардлагатай тохиолдолуудад мега төсөл болон томоохон групп компанийн эрсдэлүүдийг Мандал даатгал ХК нь тухайлсан давхар даатгалын гэрээ буюу Факультатив, Фронтинг давхар даатгалын гэрээгээр давхар даатгагчид руу тухай бүр шилжүүлэх бодлого баримталдаг. Энэ нь “Мандал Даатгал” ХК-ийн дааж чадах хэмжээнээс давсан томоохон хэмжээний хохирлын үед харилцагчдад нөхөн төлбөрийг найдвартай олгох, компани өөр дээрээ шилжүүлж авсан эрсдэлийн багцыг зөв удирдаж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад ашигладаг эрсдэлийн удирдлагын гол арга хэрэгсэл юм.

Давхар даатгагчид			
Олон улсын үнэлгээ	A+ (AM Best)	A+ (ACRA)	B (AM BEST)

ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Бид салбартаа анхдагчийн нэг болох 30 жилийн түүхт Aspire Lifestyle (HK) Limited-ын International SOS үйлчилгээг санал болгон ажиллаж байна. Уг хамгаалалт нь даатгуулагчид дэлхийн өнцөг булан бүрээс яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай үед түргэний тээвэрлэлтийн үйлчилгээг 1 сая ам.доллар хүртэлх хязгаарт багтаан үзүүлдгээрээ онцлогтой.

ДАЛД УУРХАЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

Мандал Даатгал ХК нь харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн далд уурхайн эрсдэлийн хариуцлагын даатгалуудыг Ллойдс-д бүртгэлтэй олон улсад А болон түүнээс дээш зэрэглэлтэй давхар даатгагчидтай хамтран санал болгож байна. Бид 1 сая ам доллароос 50 сая ам доллар хүртэлх байгууллагын ерөнхий хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, бохирдлын хариуцлага, ажил олгогчийн хариуцлага зэргийг давхар даатгалд 100% байршуулах боломжтой. Далд уурхайн мэргэжлийн хариуцлагын давхар даатгагчдын хувьд андеррайтингийн мэдээлэлд үндэслэн ажлын 10 хоногт багтаан үнийн саналыг хүргүүлэх боломжтой.



AA- (Standard & Poor's)

LLOYD'S

A+ (Standard & Poor's)

ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2025 онд “Мандал Даатгал” ХК нь 98.7 тэрбум төгрөгийн давхар даатгалын нийт хураамжийн орлогыг бүрдүүлж ажилласан бөгөөд уг орлогыг бүтээгдэхүүний хэлбэрээр нь задлан харвал дараах байдалтай байна:

Даатгалын хэлбэр	ДД-ын хураамжийн дүн	Эзлэх хувь
Хөрөнгийн даатгал	76,401.76	77%
Хариуцлагын даатгал	8,335.97	8%
Агаарын хөлгийн даатгал	1,810.02	2%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,138.75	1%
Бусад	11,005.20	12%
Нийт	98,691.70	100%

2025 онд “Мандал Даатгал” ХК нь нийт 4,4 тэрбум төгрөгийн 29 хувь буюу **1.3 тэрбум** төгрөгийг давхар даатгагчаар шийдвэрлүүлсэн. Нийт давхар даатгалын нөхөн төлбөрийг бүтээгдэхүүний хэлбэрээр задлан харвал дараах байдалтай


Даатгалын хэлбэр	Нөхөн төлбөрийн дүн /сая төгрөгөөр/	Эзлэх хувь
Хүнд даац тусгай зориулалтын механизм	4.15	0%
Хөрөнгийн даатгал	420.49	9%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3,987.47	90%
Бусад	29.55	1%
Нийт	4,441.66	100%

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА-2025

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

“Мандал Даатгал” ХК нь “Б-Ө-Х” (Бүтээмжтэй байх- Өгөгч байх- Харилцагчийн нүдээр харах) зарчмыг өдөр тутмынхаа ажилдаа баримталдаг бөгөөд хүний нөөцийн бодлого, чиг үүргүүд энэхүү зарчимтай уялдаатайгаар хэрэгждэг.

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ



Бид “Б-Ө-Х” зарчимдаа тулгуурлан сонгон шалгаруулалтын арга, үе шатаа сайжруулан нэвтрүүлснээр “Б-Ө-Х” зарчимд нийцсэн хандлага, ур чадвартай, ажиллаж буй салбар, ажил мэргэжлээрээ дамжуулан нийгэмдээ эерэг нөлөөлөл үзүүлэх зорилготой ажилтнуудыг эгнээндээ нэгтгэж хамтдаа баг болон ажиллаж байна. Мөн “Мандал даатгал” ХК нь “Мандал Санхүүгийн

Нэгдэл” ХХК-ийн охин компани бөгөөд компани хооронд бөгөөд, албан тушаал шилжин, дэвшин ажиллахыг хүний нөөцийн бодлогоороо дэмжин хэрэгжүүлдэг.

- Шинэ ажилтан- 50/39%
- Шилжин болон дэвшин ажилласан ажилласан- 15 ажилтан/11%

АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Мандал Даатгал” ХК нь ажилтнуудынхаа эрүүл мэнд, санхүү, карьерын сайн сайхан байдалд чиглэсэн хөтөлбөрүүдийг тасралтгүй хэрэгжүүлж байна. Санхүүгийн сайн сайхан байдалд чиглэсэн:

1. “Ажилтны хуримтлал хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү хөтөлбөр ажилтан бүрт нээлттэй. Хуримтлал нээлгэсэн ажилтан бүрийн хуримтлалд компаниас сар бүр тодорхой мөнгөн дүнгээр хуримтлал нэмж, санхүүгийн аюулгүй байдлыг дэмжин ажиллаж байна. Нийт ажилтны 40% нь энэхүү хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн тогтвортой байдлыг өөрийн амьдралын хэвшил болгон, санхүүгийн эрсдэлээс хамгаалж байна.
2. Бид ажилтнуудынхаа тээврийн хэрэгслийг хөнгөлөлттэй нөхцөлөөр даатгадаг бөгөөд 2025 онд нийт ажилтны 20 хувь нь буюу 25 ажилтан автомашинаа эрсдэлээс сэргийлэн даатгуулсан байна.

Хүний нөөцийн бодлогынхоо хүрээнд “Эрүүл ажилтан- Бүтээмжтэй ажилтан” хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ажилтан бүрийнхээ эрүүл мэндэд чиглэсэн дараах ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Ажилтнуудын эрүүл мэндэд бодитой өөрчлөлт үзүүлэх зорилгоор “Өглөөний цай хөтөлбөр”-ийг 2025 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Өглөөний цайны эрүүл мэндэд үзүүлэх ач холбогдлыг ойлгуулах сургалтыг нийт ажилтнуудаа орж, өглөө бүр ажилтнууддаа шинэхэн эрүүл хоолыг хүргэн ажилласан байна.
2. Бид ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, нөхөн төлбөрийн нийт 209 тохиолдлоос хамгаалж санхүүгийн болон эрүүл мэндийн сайн сайхан байдалд бодит дэмжлэг үзүүлсэн байна.
3. Бид 2025 онд ажилтан бүрийнхээ эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 6 төрлийн сонголтот багц бүхий эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт ажилтнуудаа хамрууллаа.
4. Улирлын шинжтэй томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх зорилгоор Сайн дурын вакцинжуулах аяныг ажилтан болон түүний гэр бүлийн гишүүдэд зориулан зохион байгууллаа. Нийт ажилтны 40% нь хамрагдсан байна.

5. Ажилтныхаа бие бялдарыг хөгжүүлж, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх зорилгоор “Йога, фитнесийн хөтөлбөр”-ийг хөнгөлөлттэй үнээр санал болгосоор ирсэн бөгөөд 2025 онд давтагдсан тоогоор 342 ажилтан хамрагдаж өөрийн эрүүл биеийг бүтээсэн байна. Мөн долоо хоног бүр багийн спортыг дэмжих, ажилтнуудынхаа чөлөөт цагийг идэвхитэй өнгөрөөх боломжийг нэмэгдүүлэн спорт заалаар ажилтнууддаа үйлчилж байна.

2025 онд Мандал санхүүгийн нэгдлийн хүрээнд 8-р сарыг ӨГӨГЧ сар болгон зарлаж нийгэмд чиглэсэн аяныг өрнүүлсэн. Үүнд:

1. Манай ажилтнууд “Амьдрал бэлэглээ” цус хандивлах аяныг зохион байгуулж, 100 гаруй хүнд зүрх бэлэглэсэн байна.
2. Мандал даатгалын ажилтнууд хичээлийн шинэ жилд зориулан хичээлийн хэрэгслийн дэмжлэг шаардлагатай 20 хүүхдүүдэд иж бүрэн хичээлийн хэрэгслийг хамтдаа бүрдүүлж, бэлэглэсэн.
3. Мандал студент хөтөлбөрийг 2 дах жилдээ Мандал Санхүүгийн Нэгдлийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлээ. 2025 онд 1000 гаруй оюутан, сурагчдаас шалгарсан 15 оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олголоо. Ингэснээр 2024-2025 онуудад нийт 28 оюутан сургалтын төлбөрийн тэтгэлэг хүргэж, ажлын байртай болжээ.
4. 2025.10 сард Компьютерийн шинжлэх ухаанаар суралцдаг оюутнууд дунд “Тэтгэлэгт оюутан хөтөлбөр”-ийг нээлттэй зарлан 3 шилдэг оюутанд 1 жилийн сургалтын төлбөрийг бүрэн олгож, ажлын гараагаа “Мандал Даатгал” ХК-иас хийх боломжийг бүрдүүлээ.

Өгөгч зарчимдаа тулгуурлан ажилтан бүрдээ өгөгч сэтгэлгээг суулгах, урам өгөх аяныг амжилттай зохион байгуулж, нийгмийн хариуцлага ажилтан бүрт чухал юм шүү гэсэн санааг хүргэж ажилласан.

Бид нийт ажилтнуудынхаа идэвх санаачлагыг дэмжих зорилгоор мөн дараах арга хэмжээг зохион байгуулсан.

- “Mandal summit” - УБ-Гачуурт шар хоолойн ам руу 8 км урт замыг үүргэвч, майхнаа үүрэн цуваагаар алхахдаа замдаа 3 удаа үдлэх, үдлэх бүртээ Б-Ө-Х зарчмын даалгавруудыг багаараа гүйцэтгэж зорилго, зарчмаа хамтдаа бататгалаа.
- Бүх ажилтны хурлыг 2025 онд 2 удаа хавар болон намрын улиралд зохион байгуулсан бөгөөд Б-Ө-Х зарчимд суурилсан захирлуудын илтгэл, хичээл, зорилтыг танилцуулсан юм.
- Open Mic чөлөөт цагийг хамт олноороо 1 өдрийг өнгөрөөх зорилготойгоор 8-р сард зохион байгуулж, авъяастай ажилтнуудаа нээн илрүүлсэн үдэш боллоо.
- Хүүхдийн баяраар компанийн нийт ажилтнуудынхаа хүүхэд бүрийн

насны онцлогт тохирсон биеийн хөгжил болон оюуны хөгжилд зориулсан 140 гаруй бэлэг бэлтгэн хүргэсэн.

- Спорт өдөрлөг Ажилтнуудыг идэвхжүүлэх, багийн ажиллагааг сайжруулах, эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой Mandal Cup-2025 спорт наадмыг спортын 5 төрлөөр 2025 оны 9 сард зохион байгууллаа.
- Амжилтын баяр нь компанийн нийт ажилтнууд оролцож 2025 оны амжилт бүтээлээ ярилцсан, танилцуулсан, Шилдэг менежер, удирдлагуудаа тодруулсан баярын хурал хэлбэрээр тэмдэглэсэн өдөр болж, Open mic-ээр тодорсон шилдэг авъяастануудаараа бүрдсэн Mandal Band-н дуучид хамт олондоо зориулсан мэндчилгээг хүргэж, халуун дулаан үдшийг өнгөрүүлсэн билээ.

СУРГАЛТ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Мандал Даатгал” ХК нь ажилтнуудынхаа сургалт хөгжлийн үйл ажиллагааг тэгш, хүртээмжтэй, системтэй зарчимд тулгуурлан зохион байгуулдаг. Ажилтан бүрийн өсөлт хөгжил, ур чадвар манай компанид хамгийн чухал юм. Энэ зорилгынхоо хүрээнд бид онлайн болон танхимын нийт 17,500 хүн цагийн сургалтыг нийт ажилтнууддаа олгожээ. Өөрөөр хэлбэл нэг ажилтан 48 цагийн сургалтад хамрагдсан нь өмнөх жилээс 4 дахин өссөн байна.

ДОТООД СУРГАЛТ- МАНДАЛ АКАДЕМИ

- Бид 2025 оны 02 сард Мандал Академи онлайн сургалтын платформын үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Бид Мандал академиараа дамжуулан 362 ажилтанд 18 бүлэг 9050 хүн цагийн сургалтыг олгосон байна.
- Мөн бид 2025 оноос эхлээд Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөрийг батлуулан нийт шинэ ажилтнуудынхаа сургалтыг танхимаар зохион байгуулж 2025 оны байдлаар нийт 880 хүн цагийн сургалтыг олгосон байна.
- Бид нийт 169 ажилтанд 8,450 хүн цагийн танхимын сургалтуудыг зохион байгуулсан.
- Бид Даатгалын залилангаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг нийт ажилтандаа өгөх онлайн болон танхимын 159 хүн цагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.
- Мөн бид харилцагчийнхаа сэтгэл ханамж, үйлчилгээгээ тасралтгүй сайжруулах зорилгоор нийт 3 удаагийн 150 хүн цагийн харилцагчийн үйлчилгээний сургалтыг харилцагчид үйлчилгээ үзүүлдэг нэгжүүддээ зохион байгуулсан.

ГАДААД СУРГАЛТ

- Бид нийт 5 ажилтнаа Сингапур улсын “Даатгалын залилангийн” сургалтад хамруулсан.
- 1 Ажилтан Cisco Certified Network Associate сургалтад хамрагдсан.
- 2 ажилтан АНУ-ын McLaren’s Business Interruption Training д хамрагдсан.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ХЭРЭГЖИЛТ

“Мандал Даатгал” ХК нь үйл ажиллагаагаа чанаржуулах, харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгоор ISO9001:2015 (Чанарын менежментийн тогтолцоо) болон ISO/IEC27001:2022 (Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо) стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, тогтмол сайжруулан ажиллаж байна.

Баталгаажуулалтын байгууллагын 2025 оны 12 сарын 24-ний өдрийн Магадлах аудитын дүгнэлтээр “Мандал Даатгал” ХК-ийн “Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалах” шийдвэр гарч, дараах үйл ажиллагааг давуу тал хэмээн дүгнэсэн:

- 5.1.1 Манлайлал ба амлалт – Дээд удирдлага нь манлайллыг дэмжиж ажилтнуудын сэтгэл ханамж болон харилцагчийн үйлчилгээнд анхаарал хандуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
- 7.1.6 Байгууллага дах мэдлэг – Б-Ө-Х (Бүтээмжтэй, Өгөгч, Харилцагчийн нүдээр харах) зарчмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн хэвшүүлсэн.
- 8.5.1 Үйлдвэрлэл явуулах, үйлчилгээ үзүүлэх ажлын хяналт – Нөхөн төлбөрийн автоматжуулалт буюу нөхөн төлбөрийн материал хүлээн авах систем хөгжүүлж, AI ашиглан нөхөн төлбөрийн дүгнэлт гаргах хөгжүүлэлтийг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.
- Уур амьсгалын өөрчлөлт – БОНЗ тайлангийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх бодитой ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Баталгаажуулалтын байгууллагын дээрх дүгнэлтээс харахад компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлж буй ажлууд нь илүү сайжирч, давуу тал болтлоо чанаржсан байна.

БОНЗ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

“Мандал Даатгал” ХК нь “Монголын Хөрөнгийн Бирж”-ийн Хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч тул зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу БОНЗ (Байгаль, орчин, нийгэм, засаглал), тогтвортой хөгжлийн тайланг 2024 онд анх удаа боловсруулан тайлагнасан.

БОНЗ, тогтвортой хөгжил хариуцсан ажлын хэсгийг 2024 онд Эрсдэлийн удирдлагын нэгжийн захирлаар ахлуулан 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон. Тус ажлын хэсэг нь БОНЗ, тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлт, тайлагналыг удирдан зохицуулж, бусад нэгж болон бүхий л оролцогч талуудын оролцоотойгоор хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Мандал Даатгал” ХК нь нийгэмд хувь нэмрээ оруулж, бодитой өөрчлөлтийг тогтмол хэрэгжүүлэх зорилгынхоо хүрээнд оролцогч талуудаа тодорхойлон, тэдгээрийн хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, эрх ашгийг нь хүндэтгэн хамтран ажилладаг.

Бид оролцогч талуудын хэрэгцээ шаардлага, хүлээлтийг ойлгохын тулд тэдэнд нөлөөлж буй асуудлууд болон учирч болох эрсдэлд дүн шинжилгээ хийснээр нийгэмд хэрэгжүүлэх ажлаа төлөвлөдөг. Бидний өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж ирсэн гол ажлууд нь олон нийтэд эрсдэлийн боловсрол олгох, нийгэм эдийн засагт тулгарч буй эрсдэлүүдийг шийдэх арга замыг эрэлхийлж, бууруулах арга хэмжээ авах бөгөөд үүнтэй холбоотой хэрэгжүүлж буй зарим ажил нь жил бүр тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээ болтлоо өргөжин, олон нийтэд хэдийнээ танигдсан билээ.

“Мандал Даатгал” ХК нь оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА – “50 ХҮНИЙ АМЬ НАС АВРАХ ТӨСӨЛ”

“АЛТЕПЛАЗА” ТӨСӨЛ

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Ашиглагдсан тун	75
Амь аврагдсан хүний тоо	38
Эмчилгээний үр дүн	100%

	Нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалтын эрсдэлийг таслан зогсоосон
Бусад	Иргэдэд ирэх эрүүл мэндийн зардлын ачааллыг 100 гаруй сая төгрөгөөр бууруулсан
	Монголын тэргүүлэх зэргийн эмнэлэгтэй стратегийн түншлэлийг бий болгосон

“ГОЛЫН ЭРГИЙН КАМЕР” – ҮЕР, УСНЫ ОСЛЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ

Улаанбаатар хот нь Туул голыг дагасан үер усны эрсдэлтэй бүсэд оршдог. Үүнийг дагаад дулааны улиралд усны ослын улмаас амь насаа алдах иргэдийн тоо эрс нэмэгддэг билээ.

“Мандал Даатгал” ХК нь “Нийслэлийн Онцгой Байдлын Ерөнхий Газар”-тай хамтран үер, усны ослыг бууруулах зорилгоор Туул голыг дагасан үер, усны ослын хамгийн өндөр эрсдэлтэй цэгүүдэд аюулыг мэдээлэх 5 цамхгийг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг ханган ажилласаар байна. Уг цамхаг нь үер, усны ослын эрсдэлтэй тохиолдлыг 200 метрийн радиуст татаж харах чадалтай хяналтын камертай ба дуут дохио ашиглан иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэдэг.

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Цамхгийн тоо	5
Хяналтын радиус	200 метр
Камер+дуут дохиотой бүс	Туул голын эрсдэл өндөртэй цэгүүд
Ослын тохиолдол буурсан байдал	3.5 дахин
Цамхгийн бүсэд тохиолдсон осол	0
Бусад	Үер, усны ослыг бууруулсан Нийслэлийн иргэлдийн аюулгүй байдлыг хангасан “Онцгой Байдлын Ерөнхий Газар”-тай итгэлцлийн түншлэлийг бий болгосон

“МАНДАЛ ЭРСДЭЛИЙН СУРГУУЛЬ” – БАГА НАСНЫ ХҮҮХДҮҮДЭД ЭРСДЭЛИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ТӨСӨЛ

Жил бүр 40,000 гаруй хүүхэд урьдчилан сэргийлэх боломжтой шалтгааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирдог гэсэн харамсалттай үзүүлэлт бий. Дөрөв дэх жилдээ хэрэгжүүлж буй уг төслийн хүрээнд 2-12 насны хүүхдүүдэд тэдний хөгжлийн онцлогт суурилан түгээмэл тохиолдох эрсдэлүүдийн талаарх 3 бүлэг 20 видео онлайн хичээлийг үнэ төлбөргүй бэлтгэн хүргэж, Нийслэлийн 400 гаруй цэцэрлэгийн сургагч багш нарт сургалтын мэдээллийг хүргэж ажилласан байна.

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Видео хичээл	20
Хамрагдсан хүүхдийн тоо	35,000 гаруй
Сургагч багш нарт мэдээлэл хүргэсэн	400 гаруй цэцэрлэгийн сургагч багш нар
Хичээл бататгах тэмцээн уралдаан	Нийт хүүхэд багачуудыг хамарсан 5 удаагийн хичээл бататгах тэмцээн уралдааныг зохион байгуулсан

“EDOCTOR” – МОНГОЛЫН АНХНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДСЭН ПЛАТФОРМ

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Тогтмол уншигч	1.5 сая
Өвчний дэлгэрэнгүй мэдээлэл	250+
Зөвлөмж нийтлэл	100+
Подкаст	35 гаруй нарийн мэргэжлийн эмч нартай хамтран өвчлөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл олгох подкастыг бэлтгэн нийтэлсэн
Бусад	Иргэдийг эрүүл мэндийн баталгаатай эх сурвалжаар хангаж ажиллаж байна Эрүүл мэндийн суурь боловсролыг нэмэгдүүлсэн

БИЗНЕСИЙН ОРЧИН, МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

“Мандал Даатгал” ХК нь жил бүр нийгэм, эдийн засагт тулгарч буй эрсдэлүүдийг шийдэх арга замыг эрэлхийлж, менежментийн арга туршлагаудаа хуваалцах зорилгоор Монголын ТОП бизнес эрхлэгчдэд зориулан “Next Leaders”, “Management Forum”, “Эрсдэлийн форум” зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг. Тус арга хэмжээнүүд нь бизнес эрхлэгчдэд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, бизнесийн хүрээлэл болон борлуулалтаа тэлэх боломжийг олгодог гэдгээрээ онцлог.

Монгол улсыг иргэдийнхээ өмнө сайн дураар өөрийнхөө бизнесийн үйл ажиллагаанаас давсан хариуцлага хүлээж чаддаг, хүнлэг том амбицтай компаниуд нэгдэн хөгжүүлж чадна гэдэгт бид итгэлтэй байдаг.

КОРПОРЕЙТ ДААТГАЛ

Мандал даатгал нь 2025 онд байгууллагын даатгалын чиглэлээр салбартаа тэргүүлэгч гэдгээ дахин баталгаажуулж, Монголын ТОП-100 аж ахуйн нэгжийн 1/3-д дангаараа даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэлээ. Тодруулбал, уул уурхай, барилга, тээвэр, худалдаа, үйлчилгээ, санхүү, үйлдвэрлэл гээд салбар салбарын тэргүүлэгч компаниудын хэрэгцээ шаардлагад нийцсэн хөрөнгө, хариуцлага, эрүүл мэнд, гэнэтийн ослын эрсдэлээс хамгаалах олон нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд санал болгож, түүний ард давхар даатгагдсан санхүүгийн найдвартай үйлчилгээний нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.

Бидний шилжүүлж авсан, дааж буй харилцагчдын эрсдэл

- Тайлант хугацаанд нийт 22 их наяд төгрөгийн дүн бүхий эрсдэлийг шинээр даатгалын хамгаалалтад хамруулж, нийт даан ажилласан эрсдэлийн хэмжээ 55 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь компанийн эрсдэлийн багцын цар хүрээ өргөжиж, зах зээлд эзлэх байр суурь бэхжсэнийг илтгэж байна. Мөн санхүүгийн чадавх, дахин даатгалын бодлого, эрсдэлийн удирдлагын тогтолцоо тогтвортой хэрэгжиж байгааг харуулж байна.

Харилцагчдад санал болгож буй үйлчилгээний давуу тал

- Тайлант хугацаанд корпорейт харилцагчдад эрсдэлийн үнэлгээнд суурилсан, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон даатгалын шийдлийг санал болгож, бизнесийн тасалдлыг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах чиглэлээр ажиллав. Харилцагч төвтэй үйлчилгээ, нөхөн төлбөрийн шуурхай шийдвэрлэлт нь байгууллагуудын эрсдэлийн удирдлагын чадавхыг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулж ажилласан.

Харилцагчийн халамж (Гарын авлага, сургалт, зөвлөмж бичлэг, мэргэжлийн өдөрлөг)

- Бид Нийгмийн үйл ажиллагаанд чиглэн жил бүр Риск Форум, Менежмент Форум, Next Leader, Investment Expo гэх зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулахын сацуу Харилцагч байгууллагынхаа эрсдлийг бууруулах үүднээс Эрсдэл үнэлгээний тайлан, Даатгалын бүтээгдэхүүний сургалт, гарын авлага, зөвлөмж бичлэг гарган өгч ажиллаж байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал нь Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын цогц харилцаа бөгөөд компанийн зорилтыг тодорхойлох, тэдгээр зорилтод хүрэх арга зам, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгодог хэрэгсэл юм.

“Мандал Даатгал” ХК-ийн эрхэм зорилго, алсын харааны салшгүй хэсэг нь сайн засаглалын туршлагыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэдэг.



“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААНЫ ТОО

Компанийн хяналт болон удирдлага нь Хувьцаа эзэмшигчид (Хувьцаа эзэмшигчдийн хурал), Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт гадаад зохицуулалт болон ТУЗ-өөс тогтоосон дотоод дүрэм, журмаар зохицуулагдан хуваарилагддаг.

	Нэрс	Тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	Юу Эм Си Капитал ХХК	297,034,325	47.58%
2	Мандал Даатгал ХК (халаасалсан)	31,215,080	5.00%
3	Олон нийт	296,052,195	47.42%
Дүн		624,301,600	100,00 %

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Мандал Даатгал” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагаатай холбоотой томоохон асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд компанийг өөрчлөн байгуулах, компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлийг батлах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох болон компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах үүрэгтэй.

“Мандал Даатгал” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 03 сарын 28-ны өдөр 12:00 цагаас компанийн албан ёсны фэйсбүүк www.facebook.com/mandaldaatgal хаягаар дамжуулан цахимаар хуралдсан.

Хурлаар дараах асуудлуудыг танилцуулж, хэлэлцэн баталсан байна. Үүнд:

1. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт танилцуулах;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн 2 гишүүнийг томилох;
6. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь компанийн урт хугацааны амжилтыг ахиулах, Хувьцаа эзэмшигчдэд тогтвортой үнэ цэнийг бий болгох, ил тод нээлттэй байдлыг эрхэмлэх болон сайн засаглалыг бий болгохыг зорьдог.

“Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнээс бүрддэг. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар томилсноор бүрэн эрх нь хэрэгжинэ.

Компанийн засаглалын кодексын дагуу ТУЗ-ийн гишүүнээр аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хүнийг сонгон ажиллуулахыг зөвлөсөн байдаг. Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо, зөвлөлийн үр ашигтай байдлыг хадгалах, дээшлүүлэхэд ихээхэн анхаардаг.

ТУЗ нь 2025 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 10 удаа хуралдаж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, 18 тогтоол шийдвэр гаргасан байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэх асуудлуудыг хэлэлцэн баталсан.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн албан ёсны фэйсбүүк хуудсаар шууд дамжуулан цахимаар хуралдах ажлыг амжилттай зохион байгуулсан.
- Компанийн стратеги, бизнес төлөвлөгөөг баталсан.
- ТУЗ-өөс баталсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж тухай бүр зөвлөмж, чиглэлийг удирдлагын багт өгч ажилласан.
- Санхүүгийн тайланд Хөндлөнгийн аудит хийх байгууллагыг ТУЗ-өөс сонгодог бөгөөд “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Нексия Глобал Монголиа” ХХК-ийг сонгосон.
- Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлаар 2025 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 14.74 төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрийг гаргасан.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан.
- Компанийн хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэрүүдийг хэлэлцэн, баталсан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Өлзийбаяр ГАНЗОРИГ | ТУЗ-ийн дарга

Ө.Ганзориг нь санхүүгийн салбарт олон жил ажиллаж буй туршлагатай боловсон хүчин юм. Тэрээр эдүгээ “Дэлхийн санхүүгийн музей”-г үүсгэн байгуулагч, “Мандал санхүүгийн нэгдэл” ХХК-ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга, “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга албыг тус тус хашиж байна.

Ө.Ганзориг нь “Монгол банк”-ны Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн, “Монголын хөрөнгийн бирж”-ийн ТУЗ-ийн гишүүн, “Санхүүгийн зохицуулах хороо”-ны Бодлогын зөвлөлийн гишүүн, Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн зөвлөлийн гишүүнээр давхар сонгогдон ажиллаж иржээ. Тэрээр мөн Голомт банкны Гүйцэтгэх захирал, Монголын банкны холбооны ерөнхийлөгч, Улаанбаатар хотын банк, Худалдаа хөгжлийн банк, Тэнгэр даатгал, Хасбанк зэрэг байгууллагад хариуцлагатай алба хашиж байсан билээ.

Ө.Ганзориг нь Олон улсын Санхүүгийн зах зээлийн холбооны Дилерийн сертификат эзэмшдэг бөгөөд Маастрихтын менежментийн сургуулийн Санхүүгийн менежментийн зэрэгтэй.

Шаравпэлжээ ГАНТУЯА | ТУЗ-ийн гишүүн

Ш.Гантуяа нь “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажилладаг. Тэрээр өмнө нь “Монгол Ньюс” ХХК-д Маркетингийн хэлтсийн захирал, “Улаанбаатар зочид буудал” ХХК-д Маркетингийн албаны дарга, “ЮуЭм Си Капитал” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

Ш.Гантуяа нь Жорж Вашингтон их сургуулийн Олон улсын Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

Түмэннасан БАТЗУЛ | ТУЗ-ийн гишүүн

Т.Батзул нь “Мандал Даатгал” ХК болон “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг. Тэрээр өмнө нь “Голомт банк” ХК-ийн Газрын захирал, “Мандал Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал, “Мандал Санхүүгийн Нэгдэл”-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан туршлагатай.

Т.Батзул нь Уэйлсийн их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

Очирпүрэв ГАНЖОЛОО | ТУЗ-ийн гишүүн

О.Ганжолоо нь “Голомт банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг. Тэрээр дэлхийн хамгийн том аудитын компани болох “Price water house Coopers”-н Герман болон Монгол дахь салбаруудад ажиллаж ихээхэн туршлага хуримтлуулсан, туршлагатай мэргэжилтэн юм. Мөн “Бодь интернэшнл” ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал, Голомт банкны ТУЗ-ийн Аудитын хорооны дарга, “Голомт Файнэншил групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байв.

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуулийн Эдийн засгийн магистр зэрэгтэй.

Лувсанжамба ГАНЗОРИГТ | ТУЗ-ийн гишүүн

Л.Ганзоригт нь “Монложистик Холдинг” ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажилладаг. Өмнө нь “Монложистик Ворлдвайд” ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал болон ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан.

Л.Ганзоригт нь ОХУ-ын Санкт Петербург хотын Кино инженерийн дээд сургуулийг Инженер мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.

Найдансүрэн МЭНДБАЯР | ТУЗ-ийн гишүүн

Н.Мэндбаяр нь “Голомт Файнэншил групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Өмнө нь “Голомт банк” ХК-ийн Аудитор, “Гэр контент групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

Н.Мэндбаяр нь Москва хотын Авто замын дээд сургуулийг Эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.

Гарамдорж ГАНТУЛГА | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Г.Гантулга нь Олон улсын Нягтлан бодох бүртгэл, Санхүүгийн мэргэшсэн сургуулийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр өмнө нь Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуульд баг, Санхүү эдийн засгийн их сургуульд Тэнхимийн эрхлэгч, багшаар ажиллаж байв.

Г.Гантулга нь Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн Нягтлан бодогч бакалавр, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн Бизнесийн удирдлагын магистр, Санхүү эдийн засгийн их сургуулийн Бизнесийн удирдлагын доктор зэрэгтэй.

Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ж.Дэлгэрсайхан нь Санхүү эдийн засгийн их сургуулийн Багш, Дэд профессороор ажилладаг. Тэрээр 1996 оноос хойш СЭЗИС-д багшлахын сацуу, олон тооны судалгаа шинжилгээ, эрдмийн бүтээл туурвиж, Монгол улсын санхүүгийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм билээ.

Ж.Дэлгэрсайхан нь Үнэт цаасны зах зээл, Хөрөнгө оруулалт, Төсөв, мөнгөний бодлогын чиглэлээр мэргэшсэн. Санхүүгийн болон бизнесийн салбарт удирдах албан тушаалтнаар ажилласан туршлагатай. Мөн Санхүүгийн зохицуулах хороо, МҮХАҮТ-ийн бодлогын зөвлөл, Ерөнхий сайдын дэргэдэх Бодлогын зөвлөлд сонгогдон ажиллаж байв.

Ж.Дэлгэрсайхан нь Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засгийн бакалавр, Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрх зүйн бакалавр, Санхүү эдийн засгийн их сургуулийн Санхүүгийн удирдлагын магистрын зэрэгтэй.

ЖЭЙМС БЕРНАРД Двайер | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Жэймс Двайер нь Нью Йорк хотод хөрөнгө оруулалтын банкираар 30 гаруй жил ажилласан туршлагатай банкир юм. Тэрээр Shearson Loeb Rhoades болон UBS зэрэг дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын банкнуудын M&A нэгжийг удирдан ажиллаж байжээ.

Жэймс Двайер нь анх 2001 онд Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын асуудлаар Монголын Засгийн газрыг төлөөлөх хөрөнгө оруулалтын банкираар Монголд зочилж байсан бөгөөд Хаан банкны хувьчлалд хөрөнгө оруулалтын зөвлөхөөр мөн ажилласан байна. Тэрээр 2007-2016 онд Монголын Бизнесийн Зөвлөл /VCM/-ийг үүсгэн байгуулж, захирлын албан тушаалыг хашиж байв.

Жэймс Двайер нь Нотр Дамын их сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.



Ө.Ганзориг
Чэйрмен



Жэймс Двайер
ТУЗ-ийн хараат бус гишүүн



О.Ганжолоо
ТУЗ-ийн гишүүн



Л.Ганзоригт
ТУЗ-ийн гишүүн



Ш.Гантуяа
ТУЗ-ийн гишүүн



Ж.Дэлгэрсайхан
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Т.Батзул
ТУЗ-ийн гишүүн



Г.Гантулга
ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ

ТУЗ-ийн ердийн гишүүн О.Ганжолоо болон Н.Мэндбаяр нарын хүсэлтийн дагуу тэднийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дах заалтыг үндэслэн ТУЗ-ийн 2025 оны 10 сарын 15-ны өдрийн №25/012 тоот тогтоолоор ТУЗ-ийн ердийн гишүүнээр Спенс Роберт Хектор Жон болон Томас Патрик Холланд нарыг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаагаар түр томилон ажиллуулсан.

Компанийн 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн ердийн гишүүнээр Спенс Роберт Хектор Жон болон Томас Патрик Холланд нарыг бусад гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл хугацаагаар томилсон.

Спенс РОБЕРТ ХЕКТОР ЖОН | ТУЗ-ийн гишүүн

Жон Спенс нь “Мандал лайф даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг. Мөн “Asian Capital Advisors” компанийн Гүйцэтгэх захирал бөгөөд Азийн даатгалын зах зээл болон бусад боломжуудад чиглэсэн стратегийн зөвлөхөөр мэргэшсэн, даатгалын технологийн бизнесийн загваруудын өсөлтийг дэмжих чиглэлээр ажилласан арвин туршлагатай.

Жон Спенс нь Сидней их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй, Нью Саут Уэльс их сургуулийг Бизнесийн магистр зэрэгтэй төгссөн.

Томас Патрик ХОЛЛАНД | ТУЗ-ийн гишүүн

Томас Холланд нь “Азийн хөгжлийн санхүүжилт” компанийн Захирлаар ажилладаг. Тэрээр АСЕАН (Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг) болон Монголд төвлөрсөн Азийн хил хязгаар болон хөгжиж буй зах зээлийн тогтвортой санхүүжилтэд чиглэсэн хөрөнгө оруулалтын платформыг байгуулсан бөгөөд хөрөнгө оруулалтын чиглэлээр арвин туршлагатай.

Томас Холланд нь Корнеллийн их сургуулийг Олон улсын харилцаа мэргэжлээр бакалавр зэрэгтэй, Оксфордын их сургуулийг Тогтвортой хот байгуулалт мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Засаглалын кодексыг хэрэгжүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулан ажилладаг. ТУЗ-ийн хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон болно. Хороод нь улирал бүр тогтмол хуралдаж, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнаж, зөвлөмжийг хүргүүлдэг.

Аудит, эрсдэлийн хороо	Нэр дэвшүүлэх хороо	Цалин, урамшууллын хороо
Хорооны дарга: Г.Гантулга	Хорооны дарга: Н.Мэндбаяр	Хорооны дарга: Ш.Гантуяа
Бүрэлдэхүүн: О.Ганжолоо Ж.Дэлгэрсайхан Жэймс Бернард Двайер	Бүрэлдэхүүн: Г.Гантулга Ж.Дэлгэрсайхан	Бүрэлдэхүүн: Ж.Дэлгэрсайхан Г.Гантулга Жэймс Бернард Двайер

Чиг үүрэг:

“Аудит, эрсдэлийн хороо” нь компанийн дотоод дүрэм журам, тушаалын хяналт тавих, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянах үүрэгтэй. Мөн компанийн Дотоод аудитын нэгж болон Хөндлөнгийн аудитын байгууллага хоорондын харилцааг зохицуулах, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод, бүрэн бүтэн байдлыг шалгаж батлах, дотоод хяналтын системийг хянах, ТУЗ-д мэдээлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Чиг үүрэг:

“Нэр дэвшүүлэх хороо” нь ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын албан тушаалд тохиромжтой этгээдийг сонгох, үнэлэх шалгуурыг тодорхойлох, эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Чиг үүрэг:

“Цалин урамшууллын хороо” нь ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

“Мандал Даатгал” ХК-ийн цалин, урамшууллын тогтолцоо нь гадаад, дотоод зах зээлийн өөрчлөлт, бизнесийн урт хугацааны стратеги төлөвлөгөө, өсөлт хөгжил, санхүүгийн үр ашиг болон бүтээмжтэй уялдсан байх бөгөөд дараах зарчимд суурилдаг.

- Бизнесийн үйл ажиллагаа, стратеги зорилттой уялдуулах
- Гүйцэтгэл, бүтээмжид суурилах
- Шинийг эрэлхийлэн тасралтгүй сайжруулах

Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал нь компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүн болон ажлын гүйцэтгэл, ур чадварын үнэлгээтэй уялдах бөгөөд цалин, урамшууллын хэмжээ, түүнийг олгох шийдвэрийг Цалин, урамшууллын хороо тогтоодог.

УДИРДЛАГЫН БАГ

Балдан ЭНХТҮВШИН | Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Б.Энхтүвшин нь “Мандал Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. Тэрээр Тээвэр хөгжлийн банк, Таван богд интернэйшнл, Нано интернэйшнл болон Мандал Санхүүгийн Нэгдлийн хамаарал бүхий компаниудын санхүүгийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байсан бөгөөд банк, санхүүгийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай. Мөн тэрээр Мандал Даатгалын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Ганбат БААСАНБАТ | Дэд захирал

Г.Баасанбат нь “Мандал Даатгал” ХК-ийн Дэд захирлаар ажилладаг бөгөөд компанийн андеррайтинг, эрсдэл болон давхар даатгалын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. Тэрээр Худалдаа хөгжлийн банк, Мандал ассет менежмент, Мандал дижитал кредит, Мандал Санхүүгийн Нэгдэл зэрэг компаниудын зээл, хөрөнгө оруулалт, эрсдэлийн чиглэлийг хариуцан ажиллаж байсан бөгөөд банк, санхүүгийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай.

Дорж БАВУУГАРЬД | Мэдээлэл, технологийн газрын захирал

Д.Бавуугарьд нь “Мандал Даатгал” ХК-ийн Мэдээлэл, технологийн хэлтсийн захирлаар ажилладаг. Тэрээр Хадгаламжийн банк, Монгол шуудан банк, Төрийн банк, Улаанбаатар хотын банкинд Мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж байсан бөгөөд банк, санхүүгийн салбарт 20 гаруй жил ажилласан туршлагатай. Мөн Мандал Санхүүгийн Нэгдлийн хамаарал бүхий компаниудын мэдээлэл, технологийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Шаравпэлжээ ГАНТУЯА | Маркетинг хариуцсан захирал

Ш.Гантуяа нь “Мандал Даатгал” ХК-ийн Маркетинг хариуцсан захирал бөгөөд компанийн брендинг, ПиАр-ын стратеги, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. Тэрээр маркетингийн чиглэлээр томоохон хувийн компаниудад ажиллаж байсан бөгөөд салбартаа 10 гаруй жил ажилласан туршлагатай. Мөн компанийн Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй ажлууд болон компанийн нэрийн хуудас болсон томоохон арга хэмжээнүүдийн зохион байгуулалтыг хариуцан хэрэгжүүлдэг.

Дариймаа БИЛГҮҮН | Хүний нөөц хариуцсан захирал

Д.Билгүүн нь “Мандал Даатгал” ХК-ийн Хүний нөөц хариуцсан захирал бөгөөд компанийн хүний нөөцийн бодлого, стратеги төлөвлөлт болон түүний хэрэгжилтийг хариуцан ажиллаж байна. Тэрээр хүний нөөцийн чиглэлээр томоохон хувийн компаниудад ажиллаж байсан бөгөөд салбартаа 10 гаруй жил ажилласан туршлагатай. Мөн тэрээр Мандал Санхүүгийн Нэгдлийн Хүний нөөц хариуцсан захирлаар ажиллаж байна.

Түвшинжаргал АРИУНАА | Андеррайтингийн хэлтсийн захирал

Түвшинжаргал АРИУНАА | Андеррайтингийн хэлтсийн захирал Т.Ариунаа нь “Мандал Даатгал” ХК-ийн Андеррайтингийн хэлтсийн захирал бөгөөд компанийн андеррайтингийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Тэрээр өмнө нь Миг даатгалд Эрх зүй, нөхөн төлбөрийн газрын захирлаар ажиллаж байсан бөгөөд даатгалын салбарт Нөхөн төлбөр, хууль эрх зүйн чиглэлээр 10 гаруй жил ажилласан туршлагатай. Мөн Мандал Даатгалын Корпорейт даатгалын борлуулалтын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байсан.

Ганболд УЯНГА | Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн захирал

Г.Уянга нь “Мандал Даатгал” ХК-ийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн захирал бөгөөд компанийн эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа, гадаад ба дотоодын эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын харилцааг хариуцан ажиллаж байна. Тэрээр өмнө нь эрүүл мэндийн салбарт судалгаа, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл мэндийн боловсролын чиглэлээр Бүгд найрамдах Солонгос улс болон Тайван улсад сурч, ажиллаж, мэргэжил дээшлүүлж байсан туршлагатай. Мөн Мандал Даатгалын эрүүл мэндийн нөхөн төлбөр, эмнэлэг хамтын ажиллагаа, эрүүл мэндийн давхар даатгал, эрүүл мэндийн андеррайтингийг хариуцан ажиллаж байсан.

Пүрэв ТАМИР | Олон улсын эрүүл мэндийн даатгалын хэлтсийн захирал

П.Тамир нь “Мандал Даатгал” ХК-ийн Олон улсын эрүүл мэндийн даатгалын хэлтсийн захирал бөгөөд дотоод болон гадаад эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэйгээр ажиллаж байна. Тэрээр Signa Health Insurance, Бодь Даатгал, Тэнгэр Даатгал, Mosaic Insurance зэрэг дотоодын болон олон улсын даатгалын байгууллагад ажиллан, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүн, борлуулалт, андеррайтинг, бүтээгдэхүүн хөгжил чиглэлээр банк, санхүү, даатгалын салбарт 10 жил ажилласан туршлагатай.

Ганболд МӨНХТҮВШИН | Нөхөн төлбөрийн хэлтсийн захирал

Г.Мөнхтүвшин нь “Мандал Даатгал” ХК-ийн Нөхөн төлбөрийн хэлтсийн захирал бөгөөд компанийн нөхөн төлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хянах, сайжруулах болон нөхөн төлбөрийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийн шинэ шийдэл, инновацийг нэвтрүүлж, тасралтгүй хөгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг. Тэрээр даатгалын салбарт нөхөн төлбөрийн чиглэлээр 10 гаруй жил ажилласан туршлагатай.

Болд БАТ-ЭРДЭНЭ | Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал

Б.Бат-Эрдэнэ нь “Мандал Даатгал” ХК-ийн Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал бөгөөд компанийн эрсдэл болон актуарын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Тэрээр өмнө нь Бодь даатгал, Миг даатгал, Агула даатгал компаниудад эрсдэл, нөхөн төлбөрийн чиглэлээр удирдах албан тушаал эрхэлдэг байсан ба даатгалын салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай.

Өлзийбаяр ТӨГӨЛДӨР | Байгууллагын даатгалын хэлтсийн захирал

Ө.Төгөлдөр нь “Мандал Даатгал” ХК-ийн Байгууллагын даатгалын хэлтсийн захирал бөгөөд компанийн зорилтот харилцагчидтай хамтын ажиллагааг эхлүүлж, урт хугацааны тогтвортой харилцааг бий болгох чиг үүрэгтэйгээр борлуулалтын чиглэлээр тасралтгүй 7 жил ажиллаж байна.

1. ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО:

Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын (GRC) тогтолцооны үр нөлөөг COSO загварын 5 бүрэлдэхүүн хэсэг, 17 зарчимд тулгуурлан хараат бус байдлаар үнэлж, баталгаажуулалт хийж байна.

1.2 ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО:

Мандал санхүүгийн нэгдлийн засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоонд бодитой байх зарчимд тулгуурласан хараат бус аудитын үйлчилгээ үзүүлэх замаар Мандал санхүүгийн нэгдлийн үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэхэд оршино.

1.3 ДОТООД АУДИТЫН БҮТЭЦ, ОРОН ТОО:

Дотоод аудитын нэгж нь нийт 3 орон тоотойгоор (ахлах аудитор, аудитор, МТ-ийн аудитор) байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө, хэрэгжилтэд хараат бус, бие даасан байдлаар үнэлгээ өгч, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.4 ХАРААТ БУС БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ:

Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагааны хувьд хараат бус, бие даасан байдлыг ханган ажилладаг бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирал /МСН/-д шууд тайлагнана. Аудитын төлөвлөгөө, тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээллийг холбогдох удирдлагын түвшинд танилцуулж, хяналтын механизмыг хэрэгжүүлнэ.

1.5 ДОТООД АУДИТЫН ЭРХ МЭДЭЛ:

- Мэдээлэлд нэвтрэх эрх: Аудитыг гүйцэтгэхтэй холбоотойгоор байгууллагын бүх үйл ажиллагаа, биет болон биет бус хөрөнгө, мэдээллийн сан, баримт бичиг, тайлангуудад хязгаарлалтгүй хандах, ажилтнуудтай уулзах, тайлбар, лавлагаа авах;
- Шууд харилцаа: Гүйцэтгэх захирал болон ТУЗ-тэй ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шууд харилцах, хамтран ажиллах;
- Мэргэжлийн бие даасан байдал: Аудитын нөөцийг хуваарилах, аудитын давтамж, төрөл болон хамрах хүрээг бие даан тогтоох, шаардлагатай арга техникийг сонгох, тайлан боловсруулах;
- Дэмжлэг авах: Аудитын зорилгоор ажилтнуудаас шаардлагатай тусалцаа, мэдээлэл, баримт материалыг дараалал харгалзахгүйгээр шаардан авах.

2. ДОТООД АУДИТЫН ЧИГ ҮҮРЭГ

Дотоод аудит нь байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны зохистой байдал, үр нөлөөг хараат бусаар үнэлж, баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд Мандал санхүүгийн нэгдлийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд аудит хийж, холбогдох дүгнэлт, санал, зөвлөмжийг боловсруулан хүргүүлдэг. Түүнчлэн мэдээллийн технологи болон мэдээллийн аюулгүй байдлын хяналт, хууль тогтоомж болон дотоод бодлого, журмын нийцлийг үнэлэх, дотоод хяналтын хэрэгжилтийг шалгах, залилан болон зөрчлийн эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зөвлөмжийг боловсруулан холбогдох нэгжүүдэд хүргүүлдэг бөгөөд байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлдэг.

3. БАРИМТЛАХ БОДЛОГО, СТАНДАРТ

Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, олон улсын стандарт болон дотоод дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

2.1 Дотоод аудиторудын институтийн (IIA) гаргасан стандарт

Дотоод аудитын нэгж нь Дотоод аудиторудын институтийн (IIA) Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн стандарт (IPPF) болон 2024 онд шинэчлэгдсэн Глобал стандартыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байгаа бөгөөд аудитор бүр ёс зүйн дараах 4 үндсэн зарчмыг мөрдөнө.

- Шударга байдал: Хийж буй ажилдаа үнэнч, хариуцлагатай хандах.
- Бодитой хандах: Шийдвэр гаргахдаа бусдын нөлөөнд автахгүй, зөвхөн баримтад тулгуурлах.
- Нууцлал: Ажлын явцад олж авсан мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй байх.
- Мэргэжлийн ур чадвар: Мэдлэг чадвараа байнга дээшлүүлж, стандартын дагуу ажиллах.

2.2 Дотоод аудитын баримт бичгүүд

Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ дараах байгууллагын дотоод бодлого, журмуудыг баримтлан ажиллаж байна. Дотоод аудитын нэгж нь дараах баримт бичгийг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Үүнд:

- Дотоод аудитын нэгжийн бодлого: Дотоод аудитын зорилго,

зорилтуудыг биелүүлэх, ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох үйл ажиллагааны үндсэн чиг баримтлал.

- Дотоод аудитын нэгжийн дүрэм: Дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тодорхойлсон албан ёсны баримт бичиг.
- Байгууллагын ёс зүйн дүрэм: Мандал даатгал ХК болон Тэнгэр даатгал ХК-ийн ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээ.